



**НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/199

Улаанбаатар хот

Өрхийн эрүүл мэндийн төвийн
гүйцэтгэлийн гэрээ байгуулж, хэрэгжилтэд
хяналт тавьж, дүгнэх ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн “Журам, гэрээний загвар, шалгуур үзүүлэлт батлах тухай” А/104 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэрээгээр хүлээсэн үүргээ “Бүрэн хангалттай”, “Хангалттай”, үнэлгээтэй биелүүлсэн Дүүргийн 1-22 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төвтэй нэг жилийн хугацаатай гүйцэтгэлийн гэрээг байгуулсугай.

2. Гүйцэтгэлийн гэрээг дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Гэрээний хэрэгжилтэд явцын хяналт хийж, бүтэн жилээр дүгнэн, ажил дүгнэсэн тухай болон цаашид зохион байгуулах үйл ажиллагааны талаарх санал, дүгнэлтээ Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Ажлын хэсэг (С.Мөнхзаяа)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Нарангэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.СУМЬЯАБААТАР

Баянгол дүүргийн Засаг даргын
2022 оны 05 дугаар сарын 24 ний өдрийн
4/199 дугаар захирамжийн хавсралт



ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛЖ, ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ ТАВЬЖ, ГЭРЭЭ ДҮГНЭХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга: Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Эрүүл мэндийн төвийн Чанарын албаны дарга

Гишүүд: Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар Нийгмийн хөгжлийн хэлтсийн Эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн төвийн Нийгмийн эрүүл мэндийн тусламж хариуцсан орлогч дарга

Эрүүл мэндийн төвийн Өрхийн менежер

Эрүүл мэндийн төвийн Халдвар судлаач

Эрүүл мэндийн төвийн Эх барих эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн ерөнхий зохицуулагч

Эрүүл мэндийн төвийн Хүүхдийн ерөнхий эмч

Эрүүл мэндийн төвийн Чанарын менежер

Монголын өрхийн Анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбооны төлөөлөл (зөвшилцсөнөөр)

Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар Санхүү төрийн сангийн хэлтсийн Ерөнхий нягтлан бодогч